

ШИНЖЭЭЧ СОНГОХ ЗАРЛАЛ

Дугаар 03-02

2021оны 04 дүгээр сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

Үндэсний Аудитын газар нь Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “Шинэчлэн сайжруулах-барих-ашиглах-шилжүүлэх, барих шилжүүлэх” төрлөөр “Дархан-Сэлэнгийн бүсэд уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн “Дулаанхааны 4 замын уулзвараас Ерөө-Хүдэр сум чиглэлийн 95 км хатуу хучилттай авто зам барих төсөл”-ийн зураг төсөл, төсөв болон ажлын гүйцэтгэлд дүгнэлт гаргах шинжээч сонгон шалгаруулж, зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулахаар төлөвлөж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хувь хүн/баг/, хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү үйл ажиллагаа нь Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ын хүрээнд хэрэгжих болно.

Шинжээч нь дээрх төслийн зураг төсөл, төсөвт өртөг нь норм, норматив, стандартын дагуу зохиогдсон эсэх, барилга угсралтын ажлыг зураг, төслийн дагуу чанартай гүйцэтгэсэн эсэх, зураг, төсөл зохиогч болон захиалагчийн хяналт үр дүнтэй хийгдсэн эсэх талаар мэргэжлийн дүгнэлт гаргаж холбогдох зөвлөмж боловсруулна.Үүнд:

Дээрх авто замын барилга байгууламжийн зураг төсөл, төсөв болон ажлын гүйцэтгэлд дүгнэлт гаргах ажлыг дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Авто зам, гүүрийн барилга байгууламжийн зураг төсөл нь холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн шаардлагыг хангаж, холбогдох төлөвлөлт, судалгаанд үндэслэсэн эсэхэд шинжээчийн дүгнэлт гаргах;
2. Авто зам, гүүрийн барилга байгууламжийн төсөв нь батлагдсан зураг төслийн дагуу холбогдох хууль тогтоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу үнэн зөв, бодитой зохиогдож, хянагдсан эсэхэд дүгнэлт гаргах;
3. Авто зам, гүүрэн байгууламжийн дараах үе шатны ажлуудад дүгнэлт гаргах;
 - *шороон далан барих ажил*
 - *хиймэл байгууламж барих ажил*
 - *суурийн ажил*
 - *хучилтын ажил*
 - *хөвөөний ажил*
 - *авто замын тоноглол, тохижилт, тэмдэг, тэмдэглэгээний ажлын гүйцэтгэлийг нягталж, дүгнэлт гаргах;*
4. Авто зам, гүүрэн байгууламжийн техник ашиглалтын түвшин тогтоох дараах ажлуудад дүгнэлт гаргах;
 - *геометр хэмжээс*
 - *хучилтын гадаргуугийн тэгш бус байдал*
 - *хучилтын зузаан*
 - *асфальт бетоны хольцын орцын шинжилгээ*
 - *битумын шинжилгээний дүгнэлт*
 - *хучилтын дундаж нягтралт*
 - *төмөрбетоны марк*
 - *гулсалтын эсэргүүцэл*
 - *хучилтын ачаа-даацын харьцааг тус тус тодорхойлж дүгнэлт гаргах*
5. Авто замын барилга байгууламжийн угсралтын үе шатны ажлуудад хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байдал, өгсөн зааварчилгаа, түүнийг хэрэгжүүлж ажилласан байдлыг нягтлан шалгах;

6. Авто замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн болон улсын комисс ажилласан бол тэдгээрээс өгсөн үүрэг даалгавар хэрэгжсэн эсэхэд дүгнэлт гаргах;

7. Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад орц, материалын тоо хэмжээ, нэр төрөл, чанар, агууламж зэргийн хувьд батлагдаж, хянагдсан төсөв болон бодит гүйцэтгэл хооронд зөрүү илэрсэн тохиолдолд гүйцэтгэлийн өртөгт үзүүлэх нөлөөллийг тогтоож, барилга угсралтын явцад төсөвт гарсан хэмнэлт, хэтрэлтийг тоо хэмжээ болон үнийн дүнгээр гаргах;

8. Авто замын барилга байгууламжийн угсралтын үе шатны ажлуудад хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байдал, өгсөн зааварчилгаа, түүнийг хэрэгжүүлж ажилласан байдлыг нягтлан шалгах;

9. Авто замын барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн болон улсын комисс ажилласан бол тэдгээрээс өгсөн үүрэг даалгавар хэрэгжсэн эсэхэд дүгнэлт гаргах;

10. Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад орц, материалын тоо хэмжээ, нэр төрөл, чанар, агууламж зэргийн хувьд батлагдаж, хянагдсан төсөв болон бодит гүйцэтгэл хооронд зөрүү илэрсэн тохиолдолд гүйцэтгэлийн өртөгт үзүүлэх нөлөөллийг тогтоож, барилга угсралтын явцад төсөвт гарсан хэмнэлт, хэтрэлтийг тоо хэмжээ болон үнийн дүнгээр гаргах.

Шинжээч нь зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхдээ Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний хөгжлийн газар, салбар хариуцсан төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллага, зураг төсвийг зохиогч, магадлал хийсэн эрх бүхий байгууллага, концесс эзэмшигч, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж зэрэг байгууллагуудаас төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлтэй холбоотой шаардлагатай баримт материалыг Үндэсний аудитын газрын аудитын багаар дамжуулан гаргуулж, бэлтгэгдсэн ажлын баримт материал, баримтат нотлох зүйлсэд үндэслэн төслийн байршил дээр үзлэг шалгалт хийх, ажлын тоо хэмжээг тулгах, дүн шинжилгээ, тооцоолол хийнэ.

Ажлыг гэрээ байгуулснаас хойш хуанлын 30 хоногт багтаан хийж гүйцэтгэнэ.

Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх шинжээч нь дээрх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээ илэрхийлсэн **албан хүсэлт, зөвлөх үйлчилгээний зорилго, зорилт, хүрэх үр дүнг илэрхийлсэн хөтөлбөр аргачлал бүхий зөвлөх багийн менежментийн төлөвлөгөө боловсруулан баталгаажуулж** ирүүлэхээс гадна дараах мэдээллийг бүрэн ирүүлнэ. Үүнд:

Хуулийн этгээд бол:

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Татварын тодорхойлолт /цахим/ ;
- Нийгмийн даатгалын тодорхойлолт /цахим/;
- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл сүүлийн 3 жилээр /2018, 2019, 2020 он/;
- Санал болгож буй ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар;
- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт /2019, 2020 оны жилийн эцсийн/;
- Тус зөвлөх үйлчилгээнд бусад зөвлөхтэй хамтран ажиллахаар шийдвэрлэсэн бол хамтран ажиллах гэрээ.

Хувь хүн/баг бол:

- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Анкет /CV/
- Боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар
- Гүйцэтгэсэн ижил төстэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/
- Багийн хувьд гишүүдийн хамтран ажиллах гэрээ

/Холбогдох тодорхойлолт нь тухайн сонгон шалгаруулалтыг зарласан цаг хугацаанд байх ба өр төлбөргүй байна./

Шинжээчид тавигдах шаардлага, ажлын туршлага:

Ажлын ерөнхий зорилтын хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлж, дүгнэлт гаргах багийн бүрэлдэхүүнд барилга байгууламжийн /Уул уурхай, металлургийн цогцолбор/ ТЭЗҮ, зураг, төсөв боловсруулах, магадлал хийх, дүгнэлт гаргах эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, эдийн засгийн үр өгөөжийг тооцох, үнэлэх талаар мэргэшсэн техникийн үйлчилгээ үзүүлж чадахуйц, тухайн салбарт ажиллаж байгаа болон ажлын дадлага, туршлагатай дүгнэлт гаргах чиглэлээр эрх бүхий зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээд байна.

Тавигдах шаардлага болон ажлын туршлагын хүрээнд гэрээт гүйцэтгэгчид дараах боловсролын тусгайлсан зэрэг, үндсэн мэргэжил, мэргэшлийн шаардлага тавигдана. Үүнд:

- Автозамын инженер;
- Авто замын зураг төсөл боловсруулах чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан, ажлын дадлага туршлагатай, мэргэшсэн инженер зэрэгтэй;
- Авто замын барилга угсралтын чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан ажлын дадлага туршлагатай, мэргэшсэн инженер зэрэгтэй;
- Авто замын болон хиймэл байгууламжийн /гүүр, ус зайлуулах хоолой/ төсөв боловсруулах, хянах, магадлал хийх эрхтэй, тэргүүлэх зэрэгтэй төсөвчин;

Шинжээчээр ажиллах боловсон хүчин нь салбартаа мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан зөвлөх зэрэгтэй инженер, эсхүл тэргүүлэх төсөвчин, эсхүл зөвлөх эдийн засагч зэрэгтэй байх;

Шинжээч нь ижил төрлийн ажил үйлчилгээг гүйцэтгэсэн туршлагатай байх.

Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтад дүгнэлт гаргах шинжээч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Санхүү, эдийн засгийн мэргэжилтэй, санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр 2-с дээш жил шинжилгээ, судалгаа хийж байсан ажлын туршлагатай байх;
- Судалгааны арга зүй ашиглаж, үнэлгээ, дүгнэлт боловсруулах ур чадвар эзэмшсэн байх;
- Багаар ажиллах чадвартай байх.

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болох ба Түншлэлийн гэрээ байгуулан баталгаажуулж ирүүлэх шаардлагатай. /Гэрээнд түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн болон түншлэлийн гишүүдийг тодорхойлж, түншлэлийн гишүүд тус бүрийн гүйцэтгэх ажил, үүргийг тусгасан байна/

Сонирхсон этгээд нь холбогдох мэдээллийг 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 10 цаг 00 минутын дотор цахим хэлбэрээр **/нэгтгэсэн pdf файлаар/** доорх хаягаар илгээнэ үү.

Хугацаа хоцорсон мэдүүлгийг хүлээн авахгүй болно.

Үндэсний аудитын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Худалдан авах үйл ажиллагаа хариуцсан шинжээч Н.Цэнд-Аюуш. tsend-ayushn@audit.gov.mn. Утасны дугаар: ажил-263533, [гар утас-88051068](tel:88051068).

Аудитын гуравдугаар газрын Аудитын менежер Б.Саруул. saruulb@audit.gov.mn Утасны дугаар: ажил-261805, гар утас-99080337

Мөн нэмэлт мэдээллийг дээрх албан тушаалтнуудаас авч болно.

Захиалагчийн хаяг: 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр, 04 дүгээр давхар,
Үндэсний Аудитын газар, Утас: 26 35 33, www.audit.mn